



ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ ХХК

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН 10-Р БАГТ
БАЙРЛАХ “ЭН ПИ ПЕТРОЛИУМ” ХХК-ИЙН ГАЗРЫН ТОСНЫ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

“ЛИМИТЭД ЭКО ПРОТЕКТ” ХХК

ЗАХИАЛАГЧ:

“ЭН ПИ ПЕТРОЛИУМ” ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо 11-
р хороолол Их тойруу 82, Одкон холдинг 309 тоот,
Утас: 99296506, 88061782

2025 ОН



АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн тодорхойлолт	3
1.2. Төслийн зорилго, зорилт	4
1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	4
1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, холбогдох утас	4
1.5. Төслийн байршил	4
1.6 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	5
1.7 Төслийн хүчин чадлын ерөнхий мэдээлэл:	5
БҮЛЭГ II. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
БҮЛЭГ III. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
БҮЛЭГ IV. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
БҮЛЭГ V. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
БҮЛЭГ VI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
БҮЛЭГ VII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН	17
БҮЛЭГ VIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
БҮЛЭГ IX. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн байршлын зураг	5
Зураг 2. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын гадна тал	8
Зураг 3. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын харагдах байдал	9
Зураг 4. Газрын тосны бүтээгдэхүүний далд сав	9
Зураг 5. Газрын тосны бүтээгдэхүүний ослын сав	10
Зураг 6. Ажилчдын амрах түр байр	10
Зураг 7. Гал унтраах хөдөлгөөнт хэрэгсэл	11

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Эргэлтийн цэгийн координат	4
Хүснэгт 2.Төслийн техникийн тодорхойлт	7
Хүснэгт 3. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт	12
Хүснэгт 4.Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	14
Хүснэгт 5.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15
Хүснэгт 6. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	16
Хүснэгт 7. Төслийн хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт	16
Хүснэгт 8. Төслийн орчны хяналт шинжилгээ хийх төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт 9. Төслийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт 10. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	18

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тодорхойлолт

“Эн Пи Петролиум” ХХК нь анх 2014 онд газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Газрын тосны бүтээгдэхүүнээ тусгай зөвшөөрөл стандартын шаардлага хангасан сав тоног төхөөрөмжүүд бүхий агуулах, шатахуун түгээх станцуудаараа дамжуулан бөөний болон жижиглэнгийн борлуулалт хийдэг.

Тос, тосолгооны материал

Моторный масло Kixx брэндийн нь GS Caltex үйлдвэрийн бүтээгдэхүүн бөгөөд БНСУ-д тосны борлуулалтаараа тэргүүлдэг бүтээгдэхүүн юм. Энэ тос нь суудлын хөнгөн тэрэг болон бага даацын ачааны машинуудын бензин хөдөлгүүрт зориулагдсан олон зэрэглэлтэй тос бөгөөд ашиглалтын бүх нөхцөлд таардаг. API SM, SL, SJ, SH буюу ILSAC GF-3 маркийн зууралдтал багатай, тосолгооны явцад ямар нэгэн байдлаар тасралт үүсдэггүй онцлогтой. Энэ нь тосыг дээд зэрэглэлийн үндсэн тосноос гарган авсан нэмэлт бодисуудыг хийж чанарыг нь сайжруулсан тул хөдөлгүүрийн эд ангиудад үүсэж эхэлж буй элэгдэл, халалтаас үүсэж болзошгүй хэв гажилт болон хөдөлгүүрт хагшаас үүсэхээс бүрэн хамгаалж, ажиллагааг мэдэгдэхүйц сайжруулсан.

Нийлүүлэлт

Улаанбаатар хот болон орон нутаг байрлах газрын тосны бүтээгдэхүүний агуулах мөн шатахуун түгээх станцуудаар дамжуулан бүтээгдэхүүнээ бөөнөөр болон жижиглэнгээр борлуулж хэрэглэгчдэдээ олон улсын стандартад бүрэн нийцсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг хүргэж байна.

Бүтээгдэхүүний чанар

Бид бүтээгдэхүүний чанарыг тэргүүнд тавьж олон улсын стандарт нийцсэн /ISO, ASTM, GOST, MNS, GB/ Амбер ХХК-ийн лабораторид бүтээгдэхүүнээ тогтмол шинжилгээнд хамруулж байна.

Салбар байршил

Улаанбаатар хот: Сонгинохайрхан дүүрэгт байрлах 4000м³ багтаамж бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулах

Хөдөө орон нутаг орон нутаг: Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 700м³-ийн багтаамж бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Ховд аймаг, Өмнөговь аймагт байрлах 4 салбартай.

Компанийн түүх

2014 он: Талын Харгуй нэртэйгээр уул уурхайн бизнесийн зөвлөгөө, гадаад худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдаж байсан түүхтэй.

2017 он: Газрын тосны тусгай зөвшөөрөл авч Баян-Өлгий аймагт ГТБА, Ховд аймгийн Дарви суманд байрлах ШТСтанцаар үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж эхэлсэн.

2018 он: “Роснефть Монголиа” ХХК-тэй гэрээ байгуулан гадаад харилцаагаа сайжруулан ажиллаж эхэлсэн. Мөн компанийн нэрээ сольж үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж төвийн бүсээр борлуулалт хийж эхэлсэн. Ховд аймгийн Үенч суманд салбараа нээсэн. УБ хотод ГТБА 1500м.кубын багтаамжтай бүхий саваар үйл ажиллагаа өргөжүүлэн ажиллаж байна. 2019: Үйл ажиллагааны цар хүрээг тэлж Өмнөговь аймагт франчайз эрхтэйгээр, Мөн Өмнөговь аймгийн Ханбогд суманд өөрийн салбарыг нээсэн.



2020 он: Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд салбараа нээн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн ажиллаж байна.

- Тос, тосолгооны материалын худалдаа эрхэлж эхэлсэн
- Үйл ажиллагаандаа дижитал шилжилтийн хүрээнд ERP нэвтрүүлж эхэлсэн

2021 он: Баян-Өлгий ГТБА савны түвшин хэмжигч суурилуулсан

- Санхүүгийн Diamond системийг халж ERP-г үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн.
- Дижитал шилжилтийн хүрээнд office 365-г ашиглан ажиллаж байна.

2022 он: УБ хотод 24/7-р ажилладаг 4000м.куб багтаамж бүхий газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг нэмэлтээр ажиллуулж байна. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоо ISO45001 стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.

1.2. Төслийн зорилго, зорилт

“Эн Пи Петролиум” ХХК компани нь ОХУ-ын Газпром нефть, Роснефть, Лукойл зэрэг үйлдвэрлэгчидтэй хамтран ажилладаг бөгөөд тос тосолгооны бүтээгдэхүүнийг өөрсдийн ШТС-аар борлуулж байна. Олон улсын стандартууд ISO 9001; ISO 45001-г нэвтрүүлж, цаашид дотоодын газрын тосны бүтээгдэхүүний импорт, жижиглэн болон бөөний борлуулалтын зах зээлд компанийн байр сууриа бэхжүүлэн, дотоодын 100 гаруй аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж, чадварлаг баг хамт олон болон хөгжихөөр зорилт тавин ажиллаж байна.

1.2.1 Төслийн нэр

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төсөл

1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

“Эн Пи Петролиум” ХХК, Улсын бүртгэлийн дугаар 1611011151, Регистрийн дугаар 5860091

1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, холбогдох утас


Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж, ЮНИОН БЮЛДИНГ “С” блок, 15-р давхар, 1508 тоот Утас: 7766 0044

1.5. Төслийн байршил

Баян-Өлгий аймаг нь баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө засах оронтой 450км, хойт талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай 225км, зүүн талаараа Увс аймагтай 165км, зүүн ба урьд талаараа Ховд аймагтай 450км нутгаар хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1301-4374 метрт оршино, нутаг дэвсгэрийн 95,3% нь 1600 метрээс дээш өндөрт байна. “Эн Пи Петролиум” ХХК-н хэрэгжүүлж буй “Газрын тосны бүтээгдэхүүний агуулах” төслийн талбайн зураглал Улаанбаатар хотоос 1760 км зайд байрладаг.

Хүснэгт 1.Эргэлтийн цэгийн координат

№	X	Y	Урт
1	5432309.271	715933.712	100.00
2	5432314.676	715833.858	100.00
3	5432414.532	715839.119	100.00
4	5432409.125	715939.119	100.00
5	5432309.271	715933.712	100.00
Нийт талбай хэмжээ 10000 м.кв			



Зураг 1.Төслийн байршлын зураг

1.6 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

1.6.1 Төслийн барилга байгууламж

Нийт 50м3*14 нийт 700м3 /далд сав/ багтаамжтай, Ачих стакад 2, Буулгах стакад 1, Оффис, ажилтны хувцас солих, амрах /Зөөврийн/ өрөө, харуулын байртай.

1.6.2 Цахилгаан хангамж

Техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа 6/0.4кВ-ын АТП-80 дэд станцын төгсгөлийн анкер тулгуураас салаалуулан 715 м АС-50 маркийн гант хөнгөнцагаан дамжуулагч бүхий ЦДАШ-аар төлөвлөж буй иж бүрэн дэд станцыг тэжээнэ.

Дэд станц: Дэд станцад ОХУ-үйлдвэрийн ТМ-6/0.4кВ-ын Sn=160кВА чадлын 1ш хүчний трансформатор суурилуулна.

1.6.3 Цэвэр усны хангамж

Ажилчдын усан хангамжыг зөөврөөр хангадаг.

1.6.4 Дулаан хангамж

Цахилгаан халаагуур ашиглаж зөөврийн ажлын байр оффисыг халаадаг.

1.6.5 Гал эсэргүүцэх цэг

Галын унтраах хөдөлгөөнт хэрэгсэл ашиглана.

1.7 Төслийн хүчин чадлын ерөнхий мэдээлэл:

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын 2016 оны 10 арын 27-ны өдрийн 223 тгт шийдвэртэй 031309610 дугаар бүхий нэгж талбартай Өлгий сумын 10-р багийн Харасай хэмээх нефтийн агуулахын зориулалтаар олгосон 10000 м.кв газрыг үндэслэн 50м3*14ширхэг далд сав 75 м3 хэвтээ далд ослын савтай, автоцистернээс 2 төрлийн бүтээгдэхүүн хүлээн авах буулгах худагтай, 2 хошуутай 1 бүтээгдэхүүний 1 ширхэг хурдны түгээгүүртэй, Тэнхлэгээрээ 12*4*8 хэмжээтэй харуул, нярав эрхлэгчийн түгээгчийн байрны барилгаас бүрдэнэ.



1.7.1 Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын мэдээлэл

Нийт 50м³*14 нийт 700м³ /далд сав/ багтаамжтай, Ачих стакад 2, Буулгах стакад 1, Оффис, ажилтны хувцас солих, амрах /Зөөврийн/ өрөө, харуулын байртай.

- 50 Кубын газрын тосны сав Газрын тосны тээврийн танк хагас чиргүүл
- Нийт L*W*H: 9500-13000*2500*3900мм (эцсийн зургаар)
- Ачаа-20000-70000 литр
- Тасалгаа-1-9 тасалгаа
- Материал-Нүүрстөрөгчийн давхар исэл Q235 / Нунтаглагч / Aluminium alloy 5454
- Гол дүнз-Стандарт онцлог хүнд даацын хүрээ сав ёроол хүртэл гагнагдсан
- Газардах төхөөрөмж-ЖОСТ буюу өргөх хүчин чадалтай тэнцэх 28 тонн
- Kingpin: 50(2 inch) #or 90(3.5inch) # бэхэлгээний төрөл
- Suspension-Механик түр саатуулах /Агаарын саатал/
- Тэнхлэг-13T/16T, FUWA/BPW/SHENGRUN гэх мэт
- Тоормосны систем-Дуал шугамын уушгины тоормос, цоорхой, холбогч

Шатахууны төрөл: ДТ, А-92 бензин хэрэглэгчдэд нийлүүлнэ.

1.7.2 Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын үйл ажиллагааны технологи

Зам талбай: Газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг ерөнхий төлөвлөгөөний дагуу, Агуулахын зам талбайд бусад зам талбайд ус орохоос хамгаалагдсан байхаар орсон хур тунадасны ус тогтоол үүсэхгүй шатахууны сав, худаг, барилга байгууламж, тусгай талбайд орохгүйгээр тооцож төлөвлөсөн.

Цэнэглэх талбай: Агуулахад шатахуун авч буй тээврийн хэрэгсэл зогсоход зориулсан цэнэглэх талбайн шатахууныг хөрсөнд нэвчүүлэхгүй байх, асгарсан шатахуунд тэсвэртэй байхаар өндөр чанарын бетоноор цементлүүлсэн.

Орлогын талбай /зогсоол/: Хөрсөнд шатахуун нэвчүүлэхгүй байх зорилгоор автоцистерн зогсох бетон талбайг төлөвлөв. Хэмжилт хийх, ачааг бүрэн буулгах зориулалтаар талбайг налуугүй тэгш байхаар төлөвлөсөн.

Шатахуун хадгалах сав: 50м³*14ширхэг далд сав 75 м³ хэвтээ далд ослын савыг далд суурилуулсан.

1. Орлогын хоолой – ф89-1
2. Сорох хоолой – ф40-1
3. Оролтын хаалт- ф80-1
4. Орлогын шүүр- ф150-1
5. Зарлагын хаалт – ф80-1
6. Дээж авах люк- ф100-1
7. Хэмжилт хийх хоолой- ф40-1

50м³ хэвтээ савны техникийн үзүүлэлт нь:

- Геометр багтаамж /м³/ - 50
- Диаметр /см/ - 3200
- Урт /м/ - 7440
- Жин /кг/- 2800
- Ажлын даралт кгс/см²- 1,7
- Вакуум даралт кгс/см²- 0,01



Технологийн хоолой: Агуулахын технологийн хоолойг ган гэрт газар дор угсрахаар зураг төсөлд тусгав. Буулгах технологийн хоолойн налуу сав уруу чиглэсэн байх ба сорох технологийн хоолой налуу технологийн худаг руу чиглэсэн байна.

Агааржуулалтын хоолой: Шатахууны төрөл тус бүрд амьсгалах клапан төлөвлөв.

Үнэртүүлэх хоолой: Шатахууны сав тус бүрд гэмтэл гарч шатахуун хөрсөнд нэвчсэн нөхцөлд мэдрэх зорилгоор төлөвлөв.

Шатахуун түгээгүүр: Агуулахад 1 төрлийн бүтээгдэхүүний 2 хошуутай 1 ширхэг түгээгүүр суурилуулсан.

Автоцистернээс буулгах төхөөрөмж: Шатахуун тээвэрлэн ирсэн автоцистернээс шатахууныг саванд хүлээн авахад зориулагдсан буулгах төхөөрөмжийг автоцистерний талбайн дэргэд буулгах хугданд байрлуулахаар төлөвлөв.

Аянга зайлуулагч: Агуулахын барилга байгууламжийг аянганаас хамгаалах зорилгоор 4 ш аянга зайлуулагч газардуулгатай.

Хүснэгт 2.Төслийн техникийн тодорхойлт

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Түгээгүүрийн байр /12м* 4.8м/	ширхэг	1
2	Хэвтээ далд сав /50м3/	ширхэг	14
3	Түгээгүүр / lanfena /	ширхэг	1
4	Түгээгүүрийн арал / 4,3м*1,3м*0,35м/	ширхэг	1
5	Ачих байгууламж	ширхэг	2
6	Буулгах худаг	ширхэг	1
7	Зарлагын худаг	ширхэг	14
8	Буулгах талбай / 12,0м*4,0м/	М,кв	48,0
9	Цэнэглэх талбай / 17.5м*4.0м/	у/м	70
10	Аянга зайлуулагч /h = 17м/	ширхэг	4
11	Ослын хэвтээ далд сав /75м3/	ширхэг	1
12	Усан сан 500м3	ширхэг	1
13	Гэрэлтүүлэгийн шон /h = 4,5м/	Иж бүрдэл	6
14	Галын сарай / 1,5м*1,3м*1,5м/	ширхэг	4
15	Металл хайс / 27,5*17,0м/	м	467.5
16	Үнийн самбар	ширхэг	1
17	Бие засах газар	ширхэг	1

Ажиллах горим: 24 цагийн турш дизель түлшийг технологийн горимын дагуу хүлээж аван, жижиглэнгээр хэрэглэгчдэд түгээнэ.

1.7.3 Технологийн үйл ажиллагаа

Ачих, буулгах байгууламж: Агуулахад автоцистернээс ДТ буулгах, ачих зориулалтын нэг зогсоолтой ачих байгууламжийг автоцистернийн зогсоолын хамт төлөвлөгдсөн.

Шатахууныг ДТ автоцистернээс ОХУ-д үйлдвэрлэсэн АСВН-80 маркын насос ашиглах буулгах ба ачихдаа мөн энэ насосоор дамжуулан ачихаар тооцсон.

Түгээх байгууламж: Хөдөө аж ахуйн зориулалтын том оврын автомашин, механизм болон дотоодын үйлчилгээний автомашин цэнэглэх зорилгоор 2 гартай түгээгүүр 1 ш техникийн үзүүлэлт 1 мин-д 150л түлш шахах хүчин чадалтай хурдны түгээгүүр

Шатахууныг автоцистернээс хүлээн авах: Автоцистернийг талбайд байрлуулж хэмжилт хийж газардуулсны дараа буулгах шлангыг холбож, буулгах хугдгийн хаалт болон автоцистерний шатахууны хаалтуудыг нээх ба буулгаж дууссаны дараагаар хаалтуудыг хаана.

Шатахууныг саванд хадгалах: Савны дүүргэлтийн дээд хязгаар нь савны паспортанд тусгайлан заагаагүй тохиолдолд бодит багтаамжийн 90 хувиас хэтрэх ёсгүй. Ашиглалтын

ердийн нөхцөлд сав бүрэн битүүмжлэгдсэн, агаарын солилцоо зөвхөн амьсгалах клапангаар дамжин явагдах ёстой. Хадгалалтын үед саванд байгаа шатахууны түвшинг сүмбэнметр хэрэглэн гараар хэмжих боломжтой. Шатахууны хувийн жин, температурыг зөөврийн багажаар савнаас зохих журмын дагуу авсан дээжийг хэмжих аргаар тодорхойлно. Савандахь бүтээгдэхүүний дээжийг зориулалтын дээж авах люкээр зөөврийн дээж авагч хэрэглэн авна.

1.7.4 Галын аюулаас сэргийлэх, гал унтраах арга хэмжээ

Гал түймэр унтраах арга: Агуулахад гарсан гал түймрийг орон нутгийн галын байгууллагын хүчний тусламжтайгаар унтраана.

Галын анхан шатны багаж хэрэгсэл: Бага хэмжээний галыг тархаахгүй унтраах зориулалтаар агуулахад нормт галын анхан шатны багаж хэрэгсэл бүхий галын сарай байрлуулсан.

Статик цэнэгжилтийн хамгаалалт: Агуулахын технологийн тоног төхөөрөмжийг статик цэнэгжилтээс хамгаалахын тулд газардуулгын хүрээг төлөвлөв. Газардуулгын эсэргүүцлийн хэмжээг жилд 2 удаа, хуурай улиралд шалгах ёстой. Шатахуун буулгаж буй автоцистернийг заавал газардуулах шаардлагатай.

Тоног төхөөрөмжийн галын аюулгүй байдал: Агуулахын тэсрэлтийн болон галын аюултай бүсүүдэд байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмж, хийц хэсгүүд нь шатдаггүй материалаар хийгдсэн, галын аюулгүй байна.



Зураг 2. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын гадна тал



Зураг 3. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын харагдах байдал



Зураг 4. Газрын тосны бүтээгдэхүүний далд сав



Зураг 5. Газрын тосны бүтээгдэхүүний ослын сав



Зураг 6. Ажилчдын амрах түр байр



Зураг 7. Гал унтраах хөдөлгөөнт хэрэгсэл



БҮЛЭГ II. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Газрын тосны бүтээгдэхүүний агуулах”-ний төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тогтоогдсон төслийн гол ба болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 3. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт			
Машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, (PM10, PM2.5)	Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын гадаад орчныг зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хийгдэх арга хэмжээ (машин техникийн тээвэрлэлт хийх, газрын тосны бүтээгдэхүүнийг буулгах талбайг тэмдэгжүүлэх, гадаад орчныг тохижуулах)	Төслийн талбай	Хатаах ууршуулах талбайг шинээр хөрсийг нь хуулж, бетондож, суурь цутгасан. Фото зургийг тайлангийн Хавсралт №01-тусгаж оруулав.
Агуулахад ажиллах ажилчдын ахуйн хог хаягдлын буруу хадгалалтаас үүсэх эвгүй үнэр орчинд тархах, амьдрах орчин доройтох зэрэг нөлөөлөл үзүүлж болзошгүй.	Талбайн орчимд усалгаа, цэвэрлэгээ хийх, автомашины явалтаар үүссэн тоосонцрыг зайлуулах. Ажилчдын ахуйн хог хаягдлыг зориулалтын сав, стандарт шаардлагад нийцүүлэн барьсан угаадасны нүхэнд цуглуулах, тээвэрлэлт, цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийж байх	Үүсэх хог хаягдал	БӨ Агуулахын хог хаягдлын энгийн болон аюултай хог хаягдал гэж ангилж БӨ аймгийн Байгаль орчны газартай хамтран ажиллаж байна. Хүрээлэн буй ойр орчмын хогийг цэвэрлэж, галын аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Фото зургийг тайлангийн Хавсралт №02-тусгаж оруулав.
Тээвэрт ашиглаж буй машин техник, нефтийн бүтээгдэхүүн буруу хадгалалтаас үүсэж болзошгүй хорт хий	Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтад тогтмол хяналт тавих, Амьсгалах клапанд болон бензин, түлш хадгалах савны битүүмжлэлд улирал бүр хяналт тавьж тохируулга хийх	Төслийн талбай	Саванд цэвэрлэн, хэмжилт хийж, таблиц шинэчлэн, хяналт тавьж тохируулга хийсэн. Хятад улсын ATA-FIRE компаниас- Сав цэвэрлэгээний тусгай ХХХ худалдан авч, үйл ажиллагаанд ашиглаж 20 сав суллаж, цэвэрлэгээ хийсэн. Фото зургийг тайлангийн Хавсралт №03-тусгаж оруулав.



	Дамжуулах хоолойнууд, тэдгээрийн холболтын эд ангиуд болон нээх-хаах хавхлагын битүүмжлэлийг байнга шалгаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын чанарт шинжилгээ хийлгэж, зөвлөгөө зөвлөмж авч байх Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын чанарт шинжилгээ хийлгэж, зөвлөгөө зөвлөмж авч байх	Төслийн талбай	ХАБЭА –н үйл ажиллагааг газар дээр нь очиж хянаж, үзлэг шалгалт хийж, сайжруулалт хийдэг. Хөдөө орон нутагт байрлах салбаруудаар томилолтоор явсан. Фото зургийг тайлангийн Хавсралт №04-тусгаж оруулав.
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт			
Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний бохирдлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад техникийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (химийн бодис, шатамхай хий, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах	Төслийн талбай	ХЭМАБ- ийн сургалт, зааварчилгааг тогтмол өгч ажилласан. Фото зургийг тайлангийн Хавсралт №05-тусгаж оруулав.
	Хатуу хог хаягдлыг цуглуулж, зохих журмын дагуу зайлуулж байх		
	Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах	Төслийн талбай	
Хөрсний үржил шимт давхаргыг хуулах хөрсний үржил шимт байдал алдагдах	Төслийн ногоон байгууламж байгуулах, мөн бүтээн байгуулалтын ажил хийхдээ өнгөн хөрсийг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт MNS 5916:2008”-д заасны дагуу хөрсний ялзмагт давхаргаас хамаарч хөрсийг хуулж, тусад нь хадгалах	Төслийн талбай	Нөхөн сэргээлтийн биелэлтийн хэсэгт тусгаж оруулсан болно.
Асгаралтын иж бүрдэл ашиглах	Шатах тослох материал асгарсан тохиолдолд асгаралтын иж бүрдэл байршуулах	Агуулахын хэсэгт	Шатах тослох материал асгарахаас бүрэн сэргийлж ажилласан.
Нефтийн бүтээгдэхүүний асгаралтын улмаас хөрсөн бүрхэвч бохирдох, хөрсний микроорганизмд нөлөөлөх	Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах Асгарсан тохиолдолд ХАЛМ (MSDS)-д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг ажлын талбарт бэлэн байлгах	Төслийн талбай	ХАЛМ- Англи болон монгол хэл дээр ХАЛМ- Хураангуй болон дэлгэрэнгүй хэлбэрээр боловсруулж, сургалтын материал бэлдсэн. Фото зургийг тайлангийн Хавсралт №06-тусгаж оруулав.
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгасан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт			
Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. Энэ нь гадаргын	Тослох шатах материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах аюулгүй ажиллагааны журам боловсруулж хэрэгжүүлэх.	Төслийн талбай	Тээврийн хэрэгсэлд тавих аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Фото зургийг тайлангийн Хавсралт №07-тусгаж



**“ЭН ПИ ПЕТРОЛИУМ” ХХК-ИЙН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах	Зам талбайн усалгаа, ногоон байгууламжын усалгаанд гүний усны эх үүсвэрийг ашиглахгүй байх, саарал ус ашиглах	Төслийн талбай	Шатахууны сав паркыг ус орох, үерээс хамгаалсан суваг, цасан шуурганаас хамгаалсан далан татсан. Фото зургийг тайлангийн Хавсралт №08-тусгаж оруулав.
	Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж		
	ШТС-ын үйл ажиллагаанд байнга хяналт тавих,нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах талбайд нефтийн бүтээгдэхүүн асгарсан байдалд хяналт тавих		
Хадгалалтын горим алдагдах буюу тусгайлан бэлтгээгүй талбайд шууд нефтийн бүтээгдэхүүнийг ачиж буулгах байрлуулах, нефтийн бүтээгдэхүүнийг орчинд алдах	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	БТБА төслийн талбайд	Шатахуунаар бохирдсон гадаргуугийн хур тунадас зайлуулах сувгийг төлөвлөх.Галын аюулгүй байдлын норм БНБД - 21.07.14 Шатахуунаар бохирдсон гадаргуугийн хур тунадас зайлуулах суваг хийсэн. Фото зургийг тайлангийн Хавсралт №09-тусгаж оруулав.
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт			
ШТС-ын хадгалалт, тээвэрлэлтээс үүсэх, тоосжилтоос шалтгаалан төслийн талбайн ургамал нөмрөг доройтох	Орчны ургамлан бүрхэвч устгах, талхлагдах, олон салаа зам гарахаас сэргийлэх, чөлөөт зорилтыг хязгаарлах арга хэмжээ авах	ГТБА төслийн талбайд	Төслийн талбайн орох гарах хэсгийг олон цугларах, тамхи татах цэгийн тэмдэг, тэмдэглэгээг тэмдэглүүлж Төслийн талбайг бүрэн цементлэж бусад хэсэгт сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байхаар ажиллаж байна. Фото зургийг тайлангийн Хавсралт №10-тусгаж оруулав.
	Замын хажуу хэсгийн ургамлыг аль болох сүйтгэхгүй байх. Машин техник тоног төхөөрөмж зөвхөн төлөвлөсөн замын дагуу явах		
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний биелэлт			
Жижиг амьтдын үүр оромж	Газар шорооны ажлын үед жижиг амьтны үүр оромж хөндөгдөж эвдэгдсэн цэгүүдэд нөхөн сэргээлт хийх	ГТБА төслийн талбайд	Төслийн талбайг агуулахын байрыг битүүжилж сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байхаар ажиллаж байна.
Нефтийн бүтээгдэхүүнээс идэх, амьсгалах зэрэг шууд замаар амьтдын аймагт сөргөөр нөлөөлнө	Нефтийн бүтээгдэхүүнийг хадгалах сав ёмкость, Агуулахын байрын битүүмжлэлийг сайжруулах, мэрэгч болон бусад амьтад нэвтрэх боломжийг бууруулах.		

БҮЛЭГ III. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжилт
Төслийн талбайн ойр орчинд мод, бут тарих	Хайлаас	Төслийн талбай	Нэмэлт ажиллагаа: 800 ширхэг үхрийн нүдний мод суулгах ажил хийгдэж дууссан. /2025.05/ 2000 ширхэг улаан лооль тариалалт хийгдсэн. /2025.06/ 6*20 хэмжээтэй 2 хүлэмжийг үйлдвэрийн талбайд угсарч байршуулсан. /2025.06/



			Хүлэмжинд огурцы, сонгино, салатны навч тариалах ажил хийж гүйцэтгэв. /2025.06/ 30-р барилгын урд талыг зүлэгжүүлэх ажил хийж гүйцэтгэв./2025.06/ Засмал зам дагуух модны хашааг засварлах ажил хийгдсэн./2025.0/ Фото зургийг тайлангийн Хавсралт №11-тусгаж оруулав.
--	--	--	--

БҮЛЭГ IV. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжилт
Байгалийн гаралтай, осол эрсдэл	Байгалийн гаралтай осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Нийт ажилчдад	Баян-өлгий аймаг дахь Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын ажилчдад “Анхан шатны тусламж үзүүлэх”, “Гамшгийн тухай ерөнхий ойлголт”, “Гал унтраагуулыг хэрхэн ажилуулах” сэдвээр сургалтыг Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын сургалт хариуцсан ажилтан дэслэгч Б.Манчук, бүлгийн ахлах ахмад А.Асанбек, Гал түймэр унтраах, аврах 31-р ангийн салааны захирагч ахлах дэслэгч Г.Алтангэрэл нар 2 цагийн сургалт зохион байгуулан ажилласан. Фото зургийг тайлангийн Хавсралт №12-тусгаж оруулав.
	Гал гарах зэрэг онцгой нөхцөлд хариу ажиллах бэлэн байдал (журам мөрдөх, ажилчдыг сургах, тоног төхөөрөмж, хэрэгсэл, хангамж),	Төслийн талбайд бэлэн байдалд байлгах	
Технологийн гаралтай осол эрсдэл	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах	Бүх ажилчдад	Ажлын хувцас, ххх –ийн өвлийн ажлын хувцасны хангалтыг тарааж ажилласан. Фото зургийг тайлангийн Хавсралт №13-тусгаж оруулав.
	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, бие эрхтнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах, эрсдэлийн санг бий болгох	Бүх ажилчдад	
	Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	Бүх ажилчдад	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан.
ШТС-ын тээвэрлэлтийн явцад үүсэж болзошгүй эрсдэл	Нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын авто тээврийн хэрэгслийг тоноглох, тээвэрлэлт явуулах үйл ажиллагааг хянах, нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх үед алдагдахад авах арга хэмжээг төлөвлөх,	Бүх ажилчдад	Тээврийн хэрэгсэлд тавих аюулгүй ажиллагааг сайжруулан ажилласан. ХЭМАБ- ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААны хүрээнд Хор саармагжуулалтын хангалтыг хийсэн. 2025 оны 5 сарын 20



	хоргүйжүүлэх зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах		1. ЭМЯ-ны “Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний жагсаалт батлах тухай” 171р тушаалын товч агуулгыг тухай танилцуулсан. 2. “Химийн бодистой харьцаж ажилладаг Ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний онцлог, доторх найрлага, ач холбогдолын тухай” сургалт орсон. Фото зургийг тайлангийн Хавсралт №14-тусгаж оруулав.
--	--	--	--

БҮЛЭГ V. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Түүх соёл өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжилт
Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хууль	2025 он	Сөрөг нөлөөлөл байхгүй болно.

БҮЛЭГ VI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Төслийн хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 5R зарчмыг баримтлан ажиллах	Төслийн талбайн хог хаягдлын эх үүсвэр	Төслийн талбайн хог хаягдлыг цэг байгуулж тогтмол хогийг ачуулж орчин тойронд хог хаягдал үүсгэхгүй тулд нийтийн цэвэрлэгээг тогтмол хийж ажиллаж байна.
	Хатуу шингэн хог хаягдлыг графикайн дагуу орон нутгаас тогтоосон зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбайгаас үүсэх хог хаягдал	Хогийн савны талбайн зургийг Хавсралт №02 т тусгасан болно.
	Авто машин механизмын ашигласан тос, тосолгооны материалыг битүү саванд хуримтлуулан хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Төслийн талбайн	Аюултай хог хаягдлыг “Сандитис” ХХК-тай байгуулсан “Аюултай хог хаягдал тээвэрлэн, устгах” гэрээний дагуу устгаж аюулгүй болгон ажиллаж байна.
	Талбайн цэвэрлэгээ хийх ба хог хаягдлыг зайлуулах явцад гүйцэтгэгч нь нийтийн болон хувийн өмчийг гэмтээхгүй ба замын хөдөлгөөнд саад учруулахгүй байх	Төслийн талбайн	Фото зургийг тайлангийн Хавсралт №15-тусгаж оруулав.



